## 2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

(Аймгийн Засаг даргын Тамгын газар)

2024 оны 06 дугаар сарын 17 Мандалговь хот

| Бүтэц | № | Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Төлөвлөсөн онд хүрэх түвшин 2024 | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ***Ерөнхий чиг үүргийн нэр: 1.* Байгалийн баялаг, байгаль орчин, аялал жуулчлал** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 1.* Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, орчны бохирдлыг бууруулах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Төв суурин газрын орчны бохирдлын түвшин бууруулна. | Агаарын чанарын индексийн түвшин | Индекс | 100> | 100> | УЦУОШТөвөөс Мандалговь хотын 1-5 дугаар сарын агаарын бохирдлыг агаарын чанарын индексээр үнэлэхэд 51 буюу хэвийн түвшинд байна. | 90 |
| | | | Бохирдсон хөрсний талбайн хэмжээ /бууралт/ | га | 113 | 103 | Төвлөрсөн хогийн цэгийн талбайн Дэлгэрцогт суманд 0.3 га талбайг шууж булшилж талбайн хэмжээг 0.3 га-аар багасгаж 128.8 га-аас 128.5 га болж буурсан. | |
| Арга хэмжээ | 1 | Утаа бага ялгаруулах төвлөрсөн халаалтын зуухны тоог нэмэгдүүлэх | 15 квт-аас дээш хүчин чадалтай зуухны тоо | тоо | 4 | 5 | Аймгийн төвийн төвлөрсөн 10 нам даралтын зууханд утаа шүүгч, "Ригал инженеринг" ХХК-тай гэрээ байгуулан 8 зууханд уутат шүүлтүүр тус тус байршуулан улсын комиссоор хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нийт 18 зууханд утаа шүүгч суурилуулснаар утаа бага ялгарах агаарын бохирдлыг 20% бууруулах боломж бүрдсэн. | |
| | 2 | Нам даралтын зуухны тоог бууруулах | Нам даралтын зуухны бууралт | тоо | 65 | 60 | Аймгийн засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/164 тоот захирамжийн дагуу байгаль орчны салбар байгууллагууд болон Авто тээврийн үндэсний төв гэсэн бүрэлдэхүүнтэй Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсэг томилогдож ажилласан. Нам даралтын зуух 87 байснаас 84 болж 3-аар буурсан. Нам даралтын зуухыг бууруулах нөхцөл нь нам даралтын зуух ашиглаж буй айл өрх, ААН байгууллагуудыг төвлөрсөн халаалтын шугам сүлжээнд холбох шаардлагатай юм. | 0 |
| | 3 | Гэр хорооллын бүсэд сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонг нэмэгдүүлэх | Гэр хорооллын сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь | Хувь | 36 | 38 | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Монголын жорлонгийн ууган холбоо ГҮТББ-тай хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Эко жорлон” арга хэмжээ зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 15 | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сумын удирдлагууд, төрийн албан хаагч, иргэд 120 хүнд Нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, Нүхэн жорлонгийн стандарт, Эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүдийн талаар сургалт зохион байгуулсан. Мөн “Эко жорлон” үзэсгэлэнгээр хуурай технологийн 8 төрөл, электрон ухаалаг нэг, ус хэмнэлтийн хуйлруулагч хошуу бүхий 2 төрөл, соруулдаг нүхэн жорлонгийн 1 төрөл нийт 13 төрлийн жорлонгийн танилцуулга, үзэсгэлэнг 200 гаруй иргэд үзэж сонирхсон байна. 2024 онд шинээр стандартын шаардлага хангасан 5 ариун цэврийн байгууламж нэмэгдэж аймгийн хэмжээнд эко ариун цэврийн байгууламжийн тоо 156 хүрч 20 хувьтай. | |
| | 4 | Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах | Цэвэрлэсэн талбайн хэмжээ | Га | 300 | 400 | БОАЖСайдын 02 дугаар албан даалгаврын хүрээнд сумдад нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 627 га талбайг цэвэрлэж 536 тн хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт төвлөрүүлсэн. Нийтийн их цэвэрлэгээнд 372 хүн оролцсон. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, булшлах | Тухай жилд шууж булшилсан талбайн хэмжээ | Га | 10 | 10 | Нийтийн эдэлбэр газарт ил задгай зөвшөөрөлгүй асгасан хог болон төвлөрсөн хогийн цэгийг Эрдэнэдалай 3 га, Луус 4 га, Баянжаргалан 0,2 га, Говь-Угтаал 5 га, Дэрэн 1 га, Гурвансайхан 5 га нийт 6 сум 18.2 га талбайг шууж булшилсан. Үүнээс төвлөрсөн хогийн цэгийн талбайн Дэлгэрцогт суманд 0.3 га талбайг шууж булшилж талбайн хэмжээг 0.3 га-аар багасгаж 128.8 га-аас 128.5 га болж буурсан. | 100 |
| | 6 | Ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх | Нэмэгдүүлсэн хогийн савны тоо | Тоо | 300 | 400 | ААН байгууллага 1, сургуульд 2, нийтийн эзэмшлийн талбайд 5, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Аймгийн төвийн нийтийн орон сууцны гадна талбайд 9 ангилан ялгах хогийн сав байршуулж аймгийн төвийн ангилан ялгах хогийн сав 81 байсан нь 98 болж нэмэгдэв. Аймгийн хэмжээнд Луус суманд 2, Сайнцагаан суманд 17 ангилан ялгах хогийн сав нэмэгдэж 311 байсан нь 330 болж нэмэгдсэн. | 30 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:2.* Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 2020 онд 28 хувь байсныг 2024 онд 44 хувьд хүргэнэ. | Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн амын эзлэх хувь | хувь | 40 | 44 | Өндөршил, Дэлгэрцогт, Луус суманд нийт 3 ус хангамжийн эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын гэрээг 3 ААНэгжтэй байгуулав. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 8 эх үүсвэрт суурилуулах | Тухайн жилд суурилуулсан төхөөрөмжийн тоо | тоо | 2 | 2 | Өндөршил, Дэлгэрцогт, Луус суманд нийт 3 ус хангамжийн эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын гэрээг 3 ААНэгжтэй байгуулав. | 30 |
| | 2 | Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Тэмдэгжүүлсэн булгийн тоо | тоо | 80 | 110 | Усны сан бүхий газарт байршуулах тэмдэг, тэмдэглэгээ нийлүүлэх ажлын гэрээг “Эйч эс си ти” ХХК-тай гэрээ байгуулав. Тус ажлын хүрээнд Өлзийт, Сайнцагаан суманд нийт 26 булгийн онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлнэ. | 30 |
| | 3 | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах | Хашсан булгийн тоо | тоо | 62 | 65 | “Дундговь” ХХК-тай гэрээ байгуулж Өлзийт сумын “Сүүжийн булаг”, “Баруун билүүний булаг”, Сайхан-Овоо сумын “Өвөр булаг” нийт 3 булгийн эхийг хашиж хамгаалах ажлын гэрээ байгуулав. | 30 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:3* Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх** ОНТ 25.0, Хувийн хэвшил 9.0 | | | | | | | | |
| Зорилт | 1 | Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байсныг 2024 онд 569.4 га-д хүргэж, ургалтын хувийг нэмэгдүүлнэ. | Ногоон байгууламжийн хэмжээ | га | 619.4 | 569.4 | Сайхан-Овоо, Баянжаргалан, Сайнцагаан сумдын төвд 10.1 га, Их газрын чулуунд 3 га, “Эрдэнэс алт ресурс” ХХК эзэмшлийн газар дээрээ 37 га нийт 50.1 га талбайд мод тарьж ногоон байгууламжийн хэмжээ 569,5 га-д хүргэв. | 100 |
| | | | Ургалтын хувь | Хувь | 78 | 80 | Ургалтын хувийг 9 дүгээр сард тооцно. Хугацаа болоогүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Тухайн жилийн сумдын ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламж хийх газрын байршил, талбайн хэмжээг тусган батлуулах | Батлуулсан сумын тоо | Тоо | 15 | 15 | 2024 оны сумдын тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламжийн зориулалтаар 7 сум 331.89 га, мод үржүүлгийн зориулалтаар 3 сум 52.52 га, нийт 384.41 га газрыг тусган батлуулсан. | 70 |
| | 2 | Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Тухайн жилд нэмэгдсэн ногоон байгууламжийн хэмжээ | Га | 5 | 5 | Сайнцагаан сумын “Аривжих төгөл”-д 6 га-д 6830 мод, “Ахмадын төгөл”-д 0,1 га-д 644 мод, Баянжаргалан сумын “Цэцэрлэгт хүрээлэн”-д 2 га-д 26000 мод, Сайхан-Овоо сумын Төгрөгийн хийдэд 2 га-д 1200 мод, нийт 10.1 га-д 34674 мод, сөөг тарьж, гүн өрмийн худаг гарган, усны нөөцийн сав, услалтын систем суурилуулан усалгаа, арчилгаа хийж байна. Хот суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувь 2.3 хувиар нэмэгдэж 13.8 хувьд хүрэв. | 100 |
| | 3 | Иргэн, ААН байгууллагыг өөрийн болон нийтийн эзэмшлийн талбайд мод сөөг тарих ажлыг зохион байгуулах | Жилд тарьсан модны тоо | Тоо | 27000 | 27000 | Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговио ногооруулъя” хөтөлбөр, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд 298 аж ахуйн нэгж, байгууллагын 1610 иргэн 118527 мод, сөөгийг тарьж цэнэг усалгаа хийж, нийт модны тоо 401936-д хүрэв. | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:4 Газрын доройтлыг бууруулах, байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх*** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2020 онд 8.3 байсныг 2024 онд 24.6 хувь болгоно. | Нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь | Хувь | 20.5 | 24.6 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газар 613.9 га түүнд ногдох нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ 2020 онд 51 га буюу 8.3 хувийг эзэлж байсан. 2024 оны 5 дугаар сарын байдлаар нийт 157.54 га-д буюу 29 хувьд хүрэв. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 80 га-р нэмэгдүүлэх | Техникийн нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | Га | 139.6 | 159.6 | Аймгийн 3 сумын нутаг дэвсгэрийн 5 байршилд уул уурхайн ашиглалт, хайгуулын үйл ажиллагаа явуулдаг 5 аж ахуйн нэгж ашиглалт, олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 4.87 га, хайгуулын үйл ажиллагаанаас эвдэрсэн 0.09 га, эзэнгүй эвдэрч орхигдсон 4.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 157.34 га-д хүрсэн. | 100 |
| | 2 | Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 20 га-р нэмэгдүүлэх | Биологийн нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | Га | 16 | 21 | 2023 онд биологийн нөхөн сэргээлт 26.52 га-д хүрсэн ба 2024 онд Дэлгэрхангай суманд 0.2 га талбайд хийгдсэнээр нийт нөхөн сэргээлтийн хэмжээ 26.72 га-д хүрэв. | 100 |
| | 3 | Уул уурхайн төслийн байгаль орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх | үр өгөөжийг нэмэгдүүлсэн төслийн тоо | Тоо | 20 | 25 | Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны өмнө хүлээх хариуцлага, үүргийг нэмэгдүүлэх | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зорилгоор үйл ажиллагаа явуулж буй 7 суманд 25 дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг төлөвлөж, эвдэрч эзэнгүй орхигдсон 4.7 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 30.000 ширхэг суулгацыг хашаа хамгаалалт, усалгааны системийн хамт нийлүүлэх, 50.000 ширхэг мод тарих арга хэмжээ авч ажиллалаа. Нийт 3 ААНэгж байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дүйцүүлэн хамгааллын 3 төсөл хэрэгжүүлж, төслийн тоо 23 болов. | |
| | 4 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулах | Нэгдсэн хяналт шалгалтын тоо | тоо | 2 | 2 | Нэгдсэн хяналт шалгалтыг 7, 10 дугаар сард хийгдэхээр төлөвлөж байна. | ХБ |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 5* Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2024 онд 33.8 хувьд хүргэнэ. | Нийт газар нутагт эзлэх хувь | хувь | 33.1 | 33.8 | Өлзийт сумын “Дэл уул, Цагаан цав-хорхойтын хөндий, Цагаан суварга” орчмын 336,490,8 га талбайг улсын тусгай хамгаалалтад авхуулахаар сум, аймгийн тогтоол гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Говь-Угтаал сумын Шарангад, Номгон, Талт толгой орчмын газруудыг сумын тусгай хамгаалалттай газруудын тогтоолыг шинэчилж газар нутгийг өргөтгөн сумын ИТХурлаар холбогдох материалыг боловсруулан ажиллаж байна. Ингэснээр улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 33.4 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүллээ. | 70 |
| Арга хэмжээ | 1 | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | Улсын тусгай хамгаалалттай нутгийн хувь | хувь | 10.2 | 10.2 | Өлзийт сумын “Дэл уул, Цагаан цав-хорхойтын хөндий, Цагаан суварга” орчмын 336,490,8 га талбайг улсын тусгай хамгаалалтад авхуулахаар сум, аймгийн тогтоол гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Ингэснээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 10.2 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүллээ. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хувь | хувь | 22.9 | 23.6 | Говь-Угтаал сумын Шарангад, Номгон, Талт толгой орчмын газруудыг сумын тусгай хамгаалалттай газруудын тогтоолыг шинэчилж газар нутгийг өргөтгөн сумын ИТХурлаар оруулахаар холбогдох материалыг боловсруулан ажиллаж байна. Ингэснээр орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ аймгийн нийт газар нутгийн 23.2 хувиас 23.6 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүлж ажиллаж байна. | 50 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 6 Биологийн олон янз байдлыг зохистой ашиглах, хамгаалах*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Биологийн олон янз байдлын нөөцийг хамгаалах, арга хэмжээний тоог нэмэгдүүлэх | Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо | Тоо | 31 | 37 | Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан зэрэгт хяналт тавьж ажилласан. Монгол тарвага"-ыг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор “Их газрын чулуу” БЦГазарт 50 тоо толгой тарвагыг нутагшуулах ажлыг “Эрдэнэс алт” ХХК холбогдох мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж нутагшуулсан. Нийт биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр 39 удаагийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 1 | Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцлийг сайжруулж, идэш тэжээлийн хомсдолоос үүссэн зүй бус хорогдлоос сэргийлж, биотехникийн арга хэмжээ авах | Биотехникийн арга хэмжээ | Тоо | 28 | 34 | Тус аймгийн улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт байрлах 6 агнуурын бүсэд 329 боодол өвс, 9 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ 37 удаа авсан. | 100 |
| | 3 | Аймгийн хэмжээнд биологийн олон янз байдлын тооллого, судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | Судалгаа хийгдсэн эсэх | /Тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Улсын тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд тус газруудын амьтан, ургамлын судалгааг “Биологийн нөөцийг хамгаалах төв” ТББ мэргэжлийн байгууллагаар хувийн хэвшлийн 15.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийилгэхээр холбогдох гэрээг байгуулан, 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллаж байна. | 70 |
| | 4 | Байгалийн ашигт ургамлыг хамгаалж, тарималжуулах | Тухайн жилд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Тоо | 1 | 1 | Ургамлын төрөлжсөн жишиг плантаци байгуулах зорилгоор Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд ашигт ургамлын жагсаалтад орсон Цулбуурт цахилдаг, Чихэр өвс зэрэг ургамлыг тарималжуулж, өсөлтийн өндөр 1,8-5,6 см ургуулав. Цаашид төрөлжсөн ховор, ашигт ургамлыг өргөжүүлэн таримжуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 |
| **Үндсэн чиг үүргийн нэр: 7 Аялал жуулчлалыг хөгжүүлэх** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | Гадаад, дотоод жуулчдын тоог 40000-д хүргэнэ. | Тухайн жилийн жуулчдын тоо | тоо | 31.0 | 40.0 | Аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын нэвтрэх цэг болон зочид буудал, жуулчны бааз, сувилал, гэр буудал, эвент арга хэмжээний нэгтгэсэн дүнгээр гадаад, дотоодын эхний 5 сарын байдлаар 4316 жуулчин ирсэн байна. | 30 |
| Арга хэмжээ | 1 | Аялал жуулчлалын гол бүс нутгийг түшиглэсэн аялал жуулчлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжиж, хүчин чадлыг нэмэгдүүлэх | Жуулчин хүлээн авах хүчин чадал | Ор хоног | 1150 | 1200 | Арилжааны банкны эх үүсвэрээр аялал жуулчлалын чиглэлээр олгох 55 тэрбумын хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээллийг аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргүүлж, 4 аж ахуйн нэгж зээлийн хүсэлтээ илгээсэн. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Бага газрын чулуунд 2 гэр буудал 20 ор хоног нэмэгдэж, аймгийн хэмжээнд ор хоногийн тоо 1188-д хүрсэн. | 90 |
| | 2 | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх | Стандартын хэрэгжилтийн үнэлгээ | Хувь | 88 | 90 | Дэлгэрцогт сумын Бага газрын чулуунд байрладаг Төв тулгат чандмань ХХК-ийн Говийн хүрхрээ жуулчны бааз 88%-тай үнэлэгдсэн бусад жуулчны баазыг 9 сараас эхэлж тохирлын үнэлгээнд хамруулна. | 70 |
| | 3 | Жуулчдын голлон зорих газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулах | Байгуулагдсан отоглох цэгийн тоо | Тоо | 4 | 5 | Гурвансайхан сумын Их газрын чулуу, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт 2 газарт “Отоглох цэг” байгуулсан. Аймгийн хэмжээнд Цагаан суваргат 1, | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Их газрын чулуунд 2, Дэл ууланд 1, нийт 4 отоглох цэг байгуулагдсан. | |
| | 4 | Олон улсын үзэсгэлэнд оролцож, орон нутгаа сурталчлах | Тухайн жилд жуулчин хүлээн авахаар байгуулсан гэрээний тоо | Тоо | 300 | 410 | Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 10 дугаар сард зохион байгуулагдана. | ХБ |
| | 5 | Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг өргөжүүлэх | Цахим үйлчилгээнд хамрагдсан ААНэгжийн тоо | Тоо | 15 | 23 | “Dundgovi” аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплекейшн, платформын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж байна. Цахим платформд 141 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл орж, 349 иргэн гар утсандаа татаж суулгасан. Гар утасны хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, мэдээлэлд тогтмол оруулж сурталчилж байна. Он гарснаас хойш 145 хэрэглэгч шинээр нэмэгдсэн. | 100 |
| | 6 | Байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн уламжлалт, өв соёлын эвент арга хэмжээ зохион байгуулах | Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо | Тоо | 3 | 3 | Сайхан-Овоо суманд Онгийн голын “Мөсний баяр” арга хэмжээ 1 дүгээр сарын 18-нд болж 3 төрлийн тэмцээн, уралдаан зохион байгуулж, 126 хүн үзэж сонирхсон. | 30 |
| | 7 | Нутгийн иргэдэд түшиглэсэн жуулчин хүлээн авах малчин өрхийн нэгдсэн сүлжээг бий болгож дэмжлэг үзүүлэх | Хамрагдсан малчин өрхийн тоо | Тоо | 30 | 40 | Нутгийн иргэдэд түшиглэсэн жуулчин хүлээн авах малчин өрхүүдийг чадавхжуулах сургалтыг 9 дүгээр сард хийхээр төлөвлөж байна. | ХБ |
| | ***Ерөнхий чиг үүргийн нэр: 2.*** **Газрын харилцаа, барилга, хот байгуулалт** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр:1.*** **Барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | 2024 он гэхэд 15 сумыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгоно. | Хөгжлийн ерөнхий төлөвлөөгөөтэй болсон сумын тоо | Тоо | 14 | 15 | 2024 оны аймгийн төсөвт Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилт 28.4 сая төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэгч Ланд Овнер ХХК-ийн ажлын удаашралаас хамаарч хойшлогдоод байна. Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авснаар Дундговь аймгийн 15 сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болох юм. | 90 |
| Арга хэмжээ | 1 | Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг боловсруулж, батлуулах | Зургийн даалгаврын тоо | Тоо | 13 | 15 | Энэ онд Дэрэн сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах шатандаа явагдаж санхүүжилт батлагдсан. | ХБ |
| | 2 | Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | Тухайн жилд хөрөнгө нь шийдвэрлэгдсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тоо | тоо | 1 | 1 | 2024 оны аймгийн төсөвт Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын үлдэгдэл санхүүжилт 28.4 сая төгрөг батлагдсан. | 100 |
| Зорилт | 2 | Ус хангамж, ариутгах татуурга, барилга байгууламжийг 6 суманд бий болгох | Сумын тоо | тоо | 8 | 9 | Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны багцад тус аймгийн "Шинэ сум" төсөл буюу Луус сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлын 1,525.0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэл 60 хувьтай үргэлжилж байна. манай аймгийн Өлзийт, Гурвансайхан, Сайхан-Овоо, | 10 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Луус сумууд ус хангамж, ариутгах татуурга, шугам сүлжээнд холбогдож байна. | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 2*** **Газрын харилцааны бодлого хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Газрын маргааны асуудал 71 байсныг 2024 онд 35 болгон бууруулна. | Шийдвэрлэсэн газрын маргааны бууралт | Тоо | 44 | 35 | Харъалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна олгогдсон газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой газрын зөрчлийн судалгааг аймгийн хэмжээнд гарган өвөлжөө, хаваржааны газрыг харъалах сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж сумын ИТХ-аар батлуулан 2021-2024 онд нийт 94 газрыг сумдын Засаг даргын захирамжаар иргэдэд эзэмшүүлэн газрын зөрчил маргааныг шийдвэрлэсэн байна | 100 |
| Арга хэмжээ | 1 | Өвөлжөө, хаваржааны газрын маргаантай газрыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, шийдвэрлэх | Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өвөлжөө хаваржааны тоо | Тоо | 7 | 6 | Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт, Дэрэн, Сайнцагаан сумдын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 35 өвөлжөө, хаваржааны газрыг төлөвлөн батлуулсан | 100 |
| | 2 | Аймаг хоорондын хил дамнан олгогдсон өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах | Тухайн жилд шийдвэрлэсэн маргааны тоо | Тоо | 3 | 3 | Төв аймгийн Баян-өндөр, Бүрэн, Өвөрхангай аймгийн Сант сумдад газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж маргааныг шийдвэрлэх тухай албан бичиг хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ***Ерөнхий чиг үүргийн нэр: 3.*** **Аймгийн эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сумдын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, хяналтыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримтлан аймгийг гадаадад төлөөлөн, гадаад ажил арга хэмжээг оновчтой төлөвлөх, үр дүнтэй зохион байгуулна.*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөрөнгө оруулалт 500 сая төгрөг байсныг 2024 он гэхэд 20 дахин нэмэгдүүлнэ. | Хөрөнгө оруулалтын хэмжээ | Сая.төг | 7,0000 | 10,000.0 | 2024 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-ийн Үдийн хоолны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төсөл, Америкийн Нэгдсэн Улсын олон улсын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилттэй Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг төсөл, БНСУ-ын "Экспорт, импорт" банкны Аймгийн төвийн "Дулааны станц барих төсөл", Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилттэй гэр сургууль хөтөлбөр, Франц Улсын сайн дурын байгууллагын Ариун цэврийн байгууламжийн төсөл, БНСУ-ын "COVA" олон улсын байгууллагын Ундны цэвэр ус төсөл зэрэг нийт 10 гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөр хэрэгжин 301,982,900 төгрөгийн санхүүжилт хийгдэв. | 100 |
| | 1 | Гадаад хамтын ажиллагаатай муж, хот, олон улсын төслийн | Нэмэгдүүлсэн улс, орнуудын муж, хотын тоо | Тоо | 5 | 6 | Хагас жилийн байдлаар Бүгд Найрамдах Польш Улсын Любельске муж, Бүгд | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | | байгууллагын тоог нэмэгдүүлэх | | | | | Найрамдах Киргиз Улсын Баткен муж, Бүгд Найрамдах Солонгос Улсын Жеолла-нам аймаг, Бүгд Найрамдах Солонгос Улсын Бие даах хөдөлмөрийн институт, нийт 4 улсын муж, хот, байгууллагатай шинээр харилцаа тогтоов. Мөн Оросын Холбооны Улсын Красноярск болон Эрхүү мужтай байгуулах гэрээний төслийг боловсруулан Гадаад харилцааны яаманд гэрээний төслийг хүргүүлэв. Нийт 2 улсын мужтай шинээр харилцаа тогтоож 2 мужтай харилцаа тогтоох шатанд арга хэмжээ хэрэгжүүлж байна. | |
| | | | Шинээр нэмэгдсэн олон улсын төслийн байгууллагын тоо | Тоо | 10 | 11 | Хагас жилийн байдлаар Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл, Японы сангийн Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл, Адаацаг суманд бэлчээрийн менежментийг сайжруулах төсөл, Өлзийт суманд “Биологийн олон янз байдлыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III төсөл” хэрэгжүүлэх төсөл, нийт 4 төсөл хөтөлбөр шинээр хэрэгжин орон нутгийн хэмжээнд 10 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. | |
| | 2 | БНХАУ-ын Баяннуур, БНСУ-ын Гуянг хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтарсан ажил, арга хэмжээ зохион байгуулах | Тухайн жилд зохион байгуулах арга хэмжээний тоо | Тоо | 2 | 2 | Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуяан хотын Дахам төрийн бус байгууллагатай хамтран Политехникийн коллеж, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан солонгос хэлний танхим байгуулсан.Баяннуур хоттой Уламжлалт анагаах ухааны хамтарсан үзлэг хийхээр бэлтгэл ажил хангаж байна. | 70 |
| | 3 | Төрийн албан хаагчдыг Гадаадад сургах, туршлага судлах арга хэмжээнд хамруулах | Тухайн жилд хамрагдсан албан хаагчдын тоо | Тоо | 30 | 40 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хот, Саньяа болон Гуанжоу хотод нийт 65 , Япон Улсад 8, Бүгд Найрамдах Солонгос Улсад 2, нийт 75 төрийн албан хаагчийг гадаадад туршлага судлах хөтөлбөрт хамруулав. | 80 |
| **Үндсэн чиг үүргийн нэр: 2. Аймгийн хэмжээний нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, сургах, давтан сургах, мэргэшүүлэх, сонгон шалгаруулах, нийгмийн баталгааг хангах, төрийн албаны хууль, ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Орон нутгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах, дутагдалтай мэргэжлийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ. | Тухайн байгууллагад 3-аас дээш жил ажиллаж байгаа ТАХ-ийн дундаж хувь | Хувь | 65 | 66 | Аймгийн хэмжээний 3270 төрийн албан хаагчийн 21255 буюу 65 хувь нь 3-аас дээш жил ажилласан төрийн албан хаагч байна. | 98 |
| | | | Дутагдалтай мэргэжлийн | Хувь | 80 | 85 | Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд аймаг | 82 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсон хүчний хангалтын хувь | | | | орон нутгийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай өндөр чадамж бүхий боловсон хүчнийг салбар бүрд тасралтгүй бэлтгэж 2020 оны байдлаар 64.9 хувтай байгаа боловсон хүчний хангалтыг 2025 онд 85 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Зорилтын хүрээнд орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй 103 оюутныг гэрээгээр бэлтгэн 2024 оны байдлаар боловсон хүчний хангалт 78 хувьд хүргээд байна. | |
| Арга хэмжээ | 1 | Орон нутагт хэрэгцээтэй боловсон хүчнийг бэлтгэх | Гэрээ байгуулсан оюутны тоо | Тоо | 40 | 45 | 2024 оны хагас жилийн байдлаар орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод докторт, МУ-ын ШУТИС, Олон улсын их сургуулиудад суралцаж байгаа 5 оюутантай гэрээ байгуулан сургалтын төлбөрийн 8.1 сая төгрөгийн тэтгэлэгт хамруулаад байна. 2024 оны 9 сард гэрээ байгуулах ажил хийгдэнэ. | 50 |
| | 2 | Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг авсан төрийн албан хаагчийн тоо | Тоо | 150 | 200 | 2024 онд “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХ-аас 450,0 сая төгрөгийг батлуулан төрийн албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалт, зөвлөгөөн, гадаад туршлага судлах, орон нутагт дутагдалтай боловсон хүчин бэлтгэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 149.4 сая төгрөгийг төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны дэмжлэг үзүүлээд байна. | |
| | 3 | Төрийн албан хаагчдыг тогтмол сургалтад хамруулах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Тоо | 1800 | 1900 | 2024 оны хагас жилийн байдлаар Удирдлагын академийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 10, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх давтан сургалтад 6, төрийн албаны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, нийт 19 төрийн албан хаагчийг улсын төсвийн санхүүжилтээр хамруулаад байна.<br>“Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд Гадаадын 5 улс оронд 23 төрийн албан хаагчийг туршлага судлах үйл ажиллагааны онгоцны зардал, томилолтын зардалд | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 89.5 сая төгрөг, орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа 5 оюутанд 8.1 сая төгрөг, Засаглалын менежмент-Нутгийн хөгжил зөвлөгөөн, Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалт, Залуучуудын хөгжлийн зөвлөлийг гишүүдийг чадваржуулах зэрэг төрийн албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх сургалт зөвлөгөөнд 39.3 нийт 58.0 сая төгрөгийг зарцуулж 492 төрийн албан хаагчийг хамруулсан байна. Засгийн газар болон салбарын яамнаас зохион байгуулсан салбар салбарын сургалтад 854 төрийн албан хаагчийг чадавхыг бэхжүүлэх сургалтад хамруулсан байна. Нийт 1346 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан байна. | |
| ***Үндсэн чиг үүрэг: 3 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Төрийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Ил тод байдлын аймгийн үнэлгээний үзүүлэлтийг 2019 онд 75 хувьтай байгааг 2024 онд 87 хувьд хүргэнэ. | Ил тод байдлын үзүүлэлт | хувь | 75 | 87 | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын 2023 оны үнэлгээний нэгдсэн дүн гараагүй байгаа бөгөөд 2023 оны жилийн эцсийн shilen.gov.mn системийн үнэлгээгээр Дундговь аймаг 98,9 хувийн үнэлгээтэй | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. 2024 оноос эхлэн улирал тутам шилэн индексийн үнэлгээг ЦХХХЯамнаас хийх бөгөөд 1-р улирлын байдлаар 82,6 хувийн үнэлгээ аваад байна. | |
| | 1 | Агентлагуудын мэдээллийн ил тод байдалд хяналт тавих, зөвлөн туслах | Тухайн жилд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо | Тоо | 8 | 10 | Shilen.gov.mn нэгдсэн системд нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг хийж мэдээлдэг болсны дагуу агентлагуудын тухайн асуудал хариуцсан ажилтнуудад цахимаар өдөр тутам мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна. 2024 оны шилэн индексийн 1,2-р улирлын үнэлгээгээр ГХБХБГ улсын хэмжээнд 97 хувиар тэргүүлж байгаа бол Статистикийн хэлтэс 96 хувийн үнэлгээгээр удаах байранд үнэлгдээд байна. | 100 |
| | 2 | Сумдын ЗДТГ-ын болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд хяналт тавих, зөвлөн туслах | Тухайн жилд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо | Тоо | 4 | 4 | Shilen.gov.mn нэгдсэн системд нээлттэй мэдээллийн ил тод байдлын мэдээллийг хэрхэн оруулах, тайлагнах заавар зөвлөмжийг сум, байгууллагуудад өдөр бүр цахимаар өгч байна. Одоогоор 4 сумын мэдээлэл үнэлгээ хийгдэж байгаа ба Цагаандэлгэр сум 76,7 хувьтай үнэлэгдсэн байна. | 100 |
| | ***Ерөнхий чиг үүргийн нэр: 4* Нутаг дэвсгэр, хүн амын аюулгүй байдал** | | | | | | | |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр: 1.* Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах** | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ. | Хэрэгжилтийн хувь | Хувь | 80 | 85 | Батлан хамгаалахын хууль, тогтоомж, тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтийг ханган 10 үйл ажиллагаа явуулж, Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах үйл ажиллагааг аймгийн төвд болон сумдад нийт 5 удаагийн сургалт, сурталчилгаа, гурван уралдаан тэмцээнийг зохион байгуулж хууль тогтоомжийн хэрэгжилтийг 85 хувьд хүргэсэн. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Цэргийн тоо бүртгэл, цэрэг татлагын үйл ажиллагааг зохион байгуулах | Хяналтын тооны биелэлтийн хувь | хувь | 96 | 98 | Дундговь аймгийн 2024 оны цэргийн бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 03-31-ны өдрүүдэд зохион байгуулсан. Аймгийн 18-60 насны цэргийн үүрэгтний хамрагдалт 76,6%-тай бүртгэлд хамрагдаж 12 төрлийн мэдээ, судалгаа, дүн шинжилгээг хугацаанд нь хүргүүлсэн. 2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын урьдчилсан үзлэгийг 04 дугаар сарын 22-28-ны өдрүүдэд Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан сумдад, нэгдсэн үзлэгийг 05 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сайнцагаан суманд зохион байгуулж ЗХЖШ-аас ирүүлсэн хяналтын тоог биелүүлсэн. | |
| | 2 | Бүх шатны Засаг дарга, Тамгын газрын дарга, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, орон нутгийн цэрэг, хамгаалалтын нэгжийн цэргийн сургалт зохион байгуулах | Хамрагдалтын хувь | Хувь | 84 | 85 | Аймгийн ИТХ, ЗДТГ хамтран 2024 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдөр Говь танхимд 61 багийн Засаг дарга нарыг хамруулан тус сургалтыг зохион байгуулсан. Сумдын ЗДТГ-ын дарга нарын Цэргийн бэлтгэл сургалт 9 дүгээр сард товлогдсон. Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу орон нутгийн цэрэг, хамгаалалтын нэгжийн хээрийн дадлага, сургалтыг Эрдэнэдалай сумд 9 сард явуулахаар төлөвлөсөн. | 50 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 2*** **. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2020 онд 60 хувьтай байсныг 2024 онд 73 хувьд хүргэнэ. | Гамшгийн эрсдэлийн бэлэн байдлын хувь | хувь | 70 | 73 | Монгол Улсын шадар сайдын баталсан гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтын удирдамж, аймгийн Засаг даргын баталсан 2024 онд гамшгаас ангиллын сургалт зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө, хуваарь, гамшгаас хамгаалах сургууль, үзлэг зохион байгуулах захирамжийн дагуу хяналт шалгалт, сургалт, сургууль, үзлэгийг зохион | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулж ажилласнаар аймгийн хэмжээнд гамшигтай тэмцэх бэлтгэл, бэлэн байдал 72,3 хувьтай хангагдсан. | |
| Арга хэмжээ | 1 | Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг орон нутгийн нийт хүн амын 30 хувийг хамруулах | Сургалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь | Хувь | 25 | 30 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу орон нутгийн хүн амд гамшгаас хамгаалах тухай мэдлэг олгох, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан, 2021-2024 оны хагас жилийн байдлаар 1430 удаагийн сургалтад иргэдийг 31729 буюу 67.5 хувийг хамруулан зохион байгуулсан. | 100 |
| | 2 | Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, жил бүр 6-аас доошгүй суманд дадлага сургууль үзлэг зохион байгуулах | Дадлага, сургууль зохион байгуулагдсан тоо | тоо | 6 | 6 | Цагаандэлгэр, Дэрэн суманд зохион байгуулах гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Дэлгэрхангай, Сайнцагаан суманд зохион байгуулах команд штабын сургуулийг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 2024 оны 03 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд гамшгаас хамгаалах сургууль үзлэг зохион байгуулах аймгийн Засаг даргын захирамж, сургуулийн удирдамж, бодлого, | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрийг боловсруулж Гурвансайхан суманд гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 2024 оны 05 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд, гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Луус, Хулд, Адаацаг, Өндөршил сумдад 2024 оны 05 дугаар сарын 08-12-ний өдрүүдэд зохион байгуулж, тус сумдын гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж ажилласан. | |
| | 3 | Гамшигтай тэмцэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх | Тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 74 | 80 | Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвд богино долгионы суурин радио станц 1, хэт богино долгионы суурин радио станц 1 байрлуулж, холбооны бэлэн байдлын хайрцагт сансрын иридиум утас 1, үүргэвчийн радио станц 1, гар станц 7, GPS 1, бэлэн байдлын ланд-80 загварын автомашинд хөдөлгөөнт старлинк төхөөрөмжүүдийг байрлуулан дуудлагаар ажиллах үед ашиглах техник хэрэгслүүдийг бэлтгэж бэлэн байдлыг хангаж, тоног төхөөрөмжийн хангалтыг 78 хувь болгосон | 100 |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 3*** **Мэргэжлийн хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт | 1 | Бага дунд эрсдэлтэй иргэн аж ахуй байгууллагын тоо 2020 онд 2774 байсныг 2024 онд 2949 болгож нэмэгдүүлнэ. | Тухайн жилд бага эрсдэлтэй үнэлэгдсэн иргэн, ААНБ-ын тоо | Тоо | 1160 | 1170 | Үнэлгээг 4 дүгээр улиралд тооцно | ХБ |
| | | | Тухайн жилд дунд эрсдэлтэй үнэлэгдсэн иргэн, ААНБ-ын тоо | Тоо | 1749 | 1779 | 21 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж 193 дутагдлыг илрүүлж улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн. | |
| Арга хэмжээ | 1 | Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг хангуулж албан шаардлагын хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэх | Тухайн жилд иргэн, ААНБ-дад өгсөн албан шаардлагын хэрэгжилтийн дундаж хувь | Хувь | 70 | 74 | Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг ариглуулахаар 31 заалт бүхий 6 албан шаардлагаар 2 ААНэгж, 4 албан хаагчдад хугацаатай үүрэг өгч ажилласан. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар албан шаардлагын хэрэгжилт 76,5%-тай байна. | 100 |
| | 2 | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн иргэн, ААНБ-ыг төлөвлөгөөт шалгалтад хамруулах | Тухайн жилд шалгалтад хамрагдах иргэн, аж ахуй нэгжийн тоо | Тоо | 350 | 360 | Хүнсний худалдааны 12, хоол үйлдвэрлэлийн 7 газар, 3 хүнсний үйлдвэр, нийт 21 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 193 дутагдал илрүүлж, 15% буюу 29 дутагдлыг тухайн газар дээр нь арилгуулсан. Бусад илэрсэн дутагдлыг арилгуулахаар 164 заалттай улсын байцаагчийн 21 албан шаардлага өгч ажилласан. Хяналт шалгалтаар дотоод хяналт шалгалт хэрэгжүүлж | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллаагүй, улсын байцаагчийн албан шаардлага биелүүлж ажиллаагүй 1 иргэн, 1 аж ахуй нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 600000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. | |
| | 3 | Иргэн, ААНБ-дад салбарын сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | Тухайн жилд сургалтад хамрагдсан иргэний тоо | Тоо | 560 | 600 | 2024 онд салбарын сургалт зохион байгуулахаар төлөвлөгдсөн. Одоогоор 1 сумын 100 малчинд “Улсын хэмжээнд баталгаажсан үүлдэр омгийн мал, түүнийг сайжруулагчаар ашиглах, малчны эрх үүрэг, хариуцлага” сэдвийн хүрээнд малчдын зөвлөгөөнөөр салбарын сургалтыг явуулж мэргэжил арга зүйн мэдээ мэдээллээр хангаад байна. Худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн удирдлага, ажилчдад “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошгод агуулагдах мэдээлэл”, “Хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт”, “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, бүртгэл хөтлөх”, "Түргэн гэмтэж, муудах эмзэг бүтээгдэхүүний хадгалалтын горим" зэрэг сэдвүүдээр байгууллагын сургалтыг зохион байгуулж, | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зориулалтын бус газарт, хүнсний бүтээгдэхүүнийг гар дээрээс худалдан борлуулахгүй байх талаар зөвлөгөө өгч, нийт 234 хүнийг хамруулсан. Сэрэмжлүүлэг 9, зөвлөмж 25-г өгч , Фейсбүүк, веб сайтад 29 удаа мэдээлэл, зөвлөмжийг байршуулсан. | |
| | 4 | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Тухайн жилд хийх урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо | Тоо | 30 | 30 | Байгууллагын даргаас өгсөн үүргээр салбарын хяналтын газраас ирүүлсэн 2024 оны 01 сарын 26-ны өдрийн 08-00-05/04 тоот удирдамжаар мэрэгчдийн талхагдлаас бэлчээрийг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажил зохион байгуулсан 8 сумын үйл ажиллагаанд явцын хяналт тавьж 9 төрлийн зөрчил дутагдал илрүүлж 4 сумын ажлын хэсгийн ахлагчид 9 заалт бүхий хугацаатай албан шаардлагаар үүрэг өгч зөрчлийг 100% арилгуулан, биелэлтийг хангуулж ажиллан хяналт шалгалтын дүн танилцуулгыг холбогдох дээд газарт хугацаанд хүргүүллээ. Цагаан сарын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад давхардсан тоогоор нийт 69 объект | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамрагдаж худалдаа 55, хоол үйлдвэрлэл 10, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч 3, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч 1, 60 аж ахуй нэгж, 9 иргэний хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрүүдийг хамруулсан байна. Хяналт шалгалтын явцад 137 зөрчлийг илрүүлэн 124 буюу 90,5%-ийг арилгуулан ажилласан. Хадгалах болон хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн 1 төрлийн 5 ширхэг 29000 төгрөгийн зөөхийг газар дээр нь устгуулж ажилласан. Өмнөх шалгалттай харьцуулахад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын горим, нөхцөл шаардлагыг мөрдөөгүй дутагдал 20%-иар буурсан, хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл тодорхойгүй, чанар аюулгүй байдлын баталгаажилт хангалтгүй дутагдал 18,8%-иар нэмэгдсэн, хяналтын байгууллагад мэдээллээ бүртгүүлээгүй дутагдал 27,7% нэмэгдсэн, хадгалалтын хугацаа дууссан болон хэрэглэх хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүн худалдсан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дутагдал 15,5%-иар буурсан байна. Зөрчил арилалтын хувь 95,2% байна. | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 4*** **Хууль ёс, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гэмт хэрэг 2019 онд 211 бүртгэгдсэн байсныг 2024 онд 190 болгон бууруулна. | Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | Тоо | 196 | 190 | Энэ оны эхний 5 сарын байдлаар 115 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 100 |
| | 2 | Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах | Зам тээврийн ослын бууралт | Тоо | 27 | 25 | Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн хяналт шалгалтыг 6 удаа зохион байгуулж, согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 122, эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 68 иргэнд торгууль оногдуулж, гарч болзошгүй зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хяналт шалгалтыг оновчтой зохион байгуулан ажилласан. Зам тээврийн осол, хэргийг бууруулах чиглэлээр "Мотоцикл ба хамгаалах малгай", "Мэдэгдэл шаардлага "сэдэвт 2 арга хэмжээг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх сургалт мэдээлэл, 16 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 860 хүнийг хамруулж, цагдаагийн газрын фейсбүүк | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуудаст постер 8, сэрэмжлүүлэг мэдээлэл 12-г байршуулж, давхардсан тоогоор 28.537 хандалт авсан байна. Энэ оны эхний 4 сарын байдлаар 4 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 42.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| | 3 | Гудамж талбай, сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлэх | Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт | Тоо | 24 | 22 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын энэ оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Мандалговь хотын төвд теле хяналтын камер нэвтрүүлэхэд шаардагдах нийт төсөвт өртөг 1.878.148.046 төгрөгийн хөрөнгийг 2024 оны төсөвт бүрэн санхүүжүүлэхээр тодотголоор баталсан. Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 20240101016 дугаартай тендерийг энэ оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 28-ны хугацаанд зарлаж, шалгаруулалт явагдан тендерийг нээж оролцсон 3 аж ахуй нэгжийг үнэлэх ажиллагаа явагдаж байна. | 70 |
| | | | Камержуулалд хийгдсэн сумын тоо | тоо | 12 | 15 | Энэ онд Дэлгэрцогт сум 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 16 ш камер, Баянжаргалан сум 10,6 сая | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгөөр төсөвт байгууллагуудын камерыг шинэчилснээр 15 сум камержсан. Энэ оны эхний 5 сарын байдлаар 8 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгжээр буюу 33,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | |
| | 4 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | Мал хулгайлах гэмт хэргийн бууралт | Тоо | 24 | 22 | Энэ оны 05 дугаар сарын 10, 25-ны өдрүүдэд тус аймгийн Дэлгэрцогт, Сайнцагаан сумдын “Малчдын зөвлөгөөн” зохион байгуулагдах үеэр нийт 350 малчдад Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах талаар 2 удаагийн сургалтын зохион байгуулсан. Зөвлөгөөний үер Дэлгэрцогт сумын 1-р баг Баянбулаг, Сайнцагаан сумын 2-р баг Тэвш багуудад малчдын 2 бүлгийг шинээр зохион байгуулсан. Энэ оны эхний 5 сарын байдлаар мал хулгайлах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр буюу 50 хувиар буурсан үзүүлэлттэй ба энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт 100 хувьтай байна. | 100 |
| Зорилт | 2 | Төрийн байгууллагуудын Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын | Стандартын хэрэгжилтийн хувь | Хувь | 89 | 90 | Нийт 30 сум, байгууллагын 60 гаруй төрийн албан хаагч болон архив бичиг хариуцсан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилт 2019 онд 86.9 хувьтай байсныг 2024 онд 90 хувьд хүргэнэ. | | | | | ажилтан нарт архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн актуудаар сургалт зохион байгууллаа. | |
| Арга хэмжээ | 1 | Сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдыг мэргэжлийн сургалтад үе шаттай хамруулах | Тухайн жилд хамрагдсан албан хаагчдын тоо | Тоо | 25 | 30 | Архивын ерөнхий газраас зохион байгуулж буй анхан болон мэргэшүүлэх шатны сургалтад хуваарийн дагуу сум, байгууллагын нийт 4 албан хаагч хамрагдсан. | 70 |
| | 2 | Сум, байгууллагыг архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр арга зүйгээр хангах | Тухайн жилд арга зүйгээр хангагдсан сум, байгууллагын тоо | тоо | 15 | 15 | Аймгийн орон нутгийг судлах Музей, Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгт очиж арга зүйн заавар зөвлөмж өгч ажилласан. Сум, байгууллагын архив бичиг хэргийн ажилтан нарыг өдөр тутмын арга зүйгээр ханган ажилласан. | 100 |
| | 3 | Сум, байгууллагууд архивд зориулалтын нягтруулсан шүүгээ болон тавиуртай болгох | Нягтруулсан шүүгээ, тавиуртай болсон сум, байгууллагын тоо | тоо | 35 | 38 | Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор нийт 32 сум, байгууллага зориулалтын нягтруулсан шүүгээ болон төмөр тавиуртай болсон. | 70 |
| Зорилт | 3 | Төрийн архивын 1970-2000 оны баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ. | Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын эзлэх хувь | хувь | 80 | 100 | Нийт баримтаас 12 хөмрөг үүсгэгч байгууллагын 794 хадгаламжийн нэгжийн баримтыг цахим хэлбэрт шинжлүүлсэн. | 70 |
| Арга хэмжээ | 1 | Төрийн архивын удирдлагын 1960-1980 оны баримтын 95 хувийг цахим хэлбэрт шилжүүлэх | Цахим хэлбэрт шилжүүлсэн хувь | Хувь | 93 | 95 | Төрийн архивд хадгалагдаж байгаа 1960-1980 оны удирдлагын баримтыг 90 хувь цахимд шилжүүлж, иргэдэд лавлагаа баримтыг цахимаас гарган үйлчилж цаасан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баримтыг байнгын ашиглалтаас гарган хамгаалалтад авсан. | |
| | 2 | Төрийн архивыг зориулалтын нягтруулсан шүүгээ болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | Нягтруулсан шүүгээний тоо | тоо | 63 | 66 | Энэ онд 2 ш нягтруулсан шүүгээгээр Төрийн архивыг хангахаар төлөвлөсөн ба 4 дүгээр улиралд хөрөнгийг нь шийдвэрлэж нийлүүлнэ. | ХБ |
